**ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД, САНГИЙН САЙД, ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2015 оны 6 дугаар сарын 26 -ны өдөр | Дугаар 248/161/А/88 | Улаанбаатар хот

Жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн жагсаалт, түүний жишиг үнэ, даатгалын сангаас олгох хэмжээ"-г нэгдүгээр, "Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр өртөг бүхий зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн зардлыг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөг бүхий мэс заслын тусламж, үйлчилгээг даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээ байгуулан, санхүүжилтийг олгож ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгуулан ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны Санхүү, эдийн засгийн хэлтэс (Т.Баярсайхан), Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар (Ж.Ганбат), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Санхүү эдийн засгийн хэлтэс (Х.Мөнхзул), Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т тус тус даалгасугай.

4.Тушаалыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаан, холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулан ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ), Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан), эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал, ерөнхий эмч нарт тус тус үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн), Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит хяналт шинжилгээ,

үнэлгээний хэлтэс (Б.Сүх-Очир), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Одбаяр)-т тус тус даалгасугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн "Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай" 380 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

7.Уг тушаалыг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

| | | |
|---|---|---|
| ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД | САНГИЙН САЙД | ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД |
| Г.ШИЙЛЭГДАМБА | Ж.ЭРДЭНЭБАТ | С.ЭРДЭНЭ |

Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн 248/161/А/88 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИХ ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЗАРИМ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, СЭРГЭЭН ЗАСАХ ЗОРИУЛАЛТААР ХИЙГДЭХ ПРОТЕЗИЙН ЖАГСААЛТ, ТҮҮНИЙ ЖИШИГ ҮНЭ, ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ХЭМЖЭЭ

| № | Олон улсын өвчний код (ICD-10) | Өвчний нэр | Хийгдэх мэс засал | Үйлдлийн олон улсын ангилал (ICD9) | Хэрэглэгдэх өндөр үнэтэй мэс заслын хэрэгсэл болон протезийн нэршил | Эмнэлгийн хэрэгсэл, протез | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Код | Жишиг үнэ /төгрөгөөр/ | Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хөнгөлөлтийн хэмжээ /төгрөгөөр/ |
| **1. ЗҮРХНИЙ ТӨРӨЛХИЙН ГАЖГИЙН МЭС ЗАСАЛ** | | | | | | | | |
| 1.1 | Q20.0 | Артерийн битүүрээгүй цорго | Артерийн битүүрээгүй цоргыг катетерийн буюу мэс заслын бус аргаар эмчлэх | 36, 39.61 | НАП-ын Амплатцер | S0001 | 1,710,000 | 1,282,500 |
| | | | | | Амплатцерийн зөөгч систем | S0002 | 570,000 | 427,500 |
| | | | | | Койл | S0003 | 688,200 | 516,150 |
| 1.2 | Q21.0 | Ховдол хоорондын таславчийн цоорхой | Цоорхойг биологийн болон синтетик нөхөөсөөр цусны зохиомол эргэлтийн нөхцөлд нөхөх мэс засал | 35.72, 39.61 | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |
| | | | | | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Пейсмейкерийн утас | S0008 | 180,000 | 135,000 |
| 1.3 | | Ховдол хоорондын таславчийн цоорхой+гурван хавтаст хавхлагын дутагдал | Цоорхойг биологийн болон синтетик нөхөөсөөр цусны зохиомол эргэлтийн нөхцөлд нөхөх + гурван хавтаст хавхлагын пластик мэс засал | 35.28, 35.72, 39.61 | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |
| 1.4 | Q21.1 | Тосгуур хоорондын таславчийн цоорхой+ гурван хавтаст хавхлагын дутагдал | Цоорхойг биологийн болон синтетик нөхөөсөөр цусны зохиомол эргэлтийн нөхцөлд нөхөх + гурван хавтаст хавхлагын пластик мэс засал | 35.28, 35.71, 39.61 | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Пейсмейкерийн утас | S0008 | 180,000 | 135,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Q21.1 | Тосгуур хоорондын таславчийн цоорхой | Цоорхойг биологийн болон синтетик нөхөөсөөр цусны зохиомол эргэлтийн нөхцөлд нөхөх мэс засал | 35.6, 35.71, 39.61 | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Пейсмейкерийн утас | S0008 | 180,000 | 135,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |
| 1.6 | | | Тосгуур хоорондын таславчийн цоорхой гажгийг катетерийн буюу мэс заслын бус аргаар эмчлэх | 35.71, 39.61 | ДМПП-ын амплатцер | S0009 | 3,902,000 | 2,926,500 |
| | | | | | Амплатцерийн зөөгч систем | S0002 | 570,000 | 427,500 |
| 2. ЗҮРХНИЙ ОЛДМОЛ ГАЖГИЙН МЭС ЗАСАЛ | | | | | | | | |
| 2.1 | I05 | Зүрхний хос хавтаст хавхлагын гажигууд | Цусны зохиомол эргэлтийн нөхцөлд Хиймэл хос хавтаст хавхлага суулгах мэс засал (эсвэл Карпентьегийн цагираг суулгах мэс засал ) | 35.24, 39.61 | Хоёр хавтасны механик хавхлага | S0010 | 2,660,000 | 1,995,000 |
| | | | | | Хавхлага оёх жийргэвчтэй утас | S0011 | 361,200 | 270,900 |
| | | | | | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Пейсмейкерийн утас | S0008 | 180,000 | 135,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |
| 2.2 | I06 | Зүрхний гол судасны хавхлагын гажигууд | Цусны зохиомол эргэлтийн нөхцөлд Хиймэл гол судасны хавхлага суулгах мэс засал | 35.22, 39.61 | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Аортын механик хавхлага | S0012 | 2,660,000 | 1,995,000 |
| | | | | | Хавхлага оёх жийргэвчтэй утас | S0011 | 361,200 | 270,900 |
| | | | | | Пейсмейкерийн утас | S0008 | 180,000 | 135,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |
| 2.3 | I07 | Зүрхний Гурван хавтаст хавхлагын гажигууд | Цусны зохиомол эргэлтийн нөхцөлд Хиймэл гурван хавтаст хавхлага суулгах мэс засал (эсвэл Карпентьегийн цагираг суулгах мэс засал ) | 35.28, 39.61 | Хавхлага оёх жийргэвчтэй утас | S0010 | 361,200 | 270,900 |
| | | | | | Пейсмейкерийн утас | S0008 | 180,000 | 135,000 |
| | | | | | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |
| 2.4 | I08 | Зүрхний Олон хавхлагын хавсарсан гажигууд | Цусны зохиомол эргэлтийн нөхцөлд Хиймэл хос хавтаст хавхлага+гол судасны хавхлага +Карпентьегийн цагираг суулгах мэс засал | 35.2, 39.61 | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Аортын механик хавхлага | S0012 | 2,660,000 | 1,995,000 |
| | | | | | Хоёр хавтасны механик хавхлага | S0010 | 2,660,000 | 1,995,000 |
| | | | | | Хавхлага оёх жийргэвчтэй утас | S0011 | 361,200 | 270,900 |
| | | | | | Пейсмейкерийн утас | S0008 | 180,000 | 135,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. ЗҮРХНИЙ ИШЕМИТ ӨВЧНИЙ ҮЕИЙН МЭС ЗАСАЛ | | | | | | | | |
| 3.1 | I20-I25 | Зүрхний цочмог шигдээс, Зүрхний бах, ачааллын болон тайван үеийн /стенокарди/ | Коронарная ангиография | 36.06, 36.07, 00.45-00.48, 00.40-00.43, 36.03, 00.66, 00.44 | Оношилгооны багц (оношилгооны катетр, сэтгүүр, ионгүй тодосгогч бодис, manifold kit) | S0013 | 112,000 | 84,000 |
| | | | | | Чиглүүлэгч | S0014 | 184,000 | 138,000 |
| | | | | | Тэлэгч зонд | S0015 | 438,800 | 329,100 |
| | | | | | Эмгүй стент | S0016 | 1,100,000 | 825,000 |
| | | | | | Эмтэй стент | S0017 | 1,366,000 | 1,024,500 |
| | | | | | Стентийн дагалдах хэрэгслүүд (дамжуулагч гуурс, урт чиглүүлэгч, автомат шприц, даралтын холбогч гуурс, ховдлын сэтгүүр, 3 кранттай хаалт, Y хэлбэрийн хаалт чиглүүлэгч зүү, эмчилгээний сэтгүүр) | S0019 | 456,000 | 342,000 |
| | | | | | Артерийн даралт хэмжигч | S0020 | 176,000 | 132,000 |
| | | | | | Манометр | S0021 | 70,000 | 52,500 |
| 3.2 | I20-I29 | Зүрхний ишеми өвчин | Цусны зохиомол эргэлтийн нөхцөлд Титэм судасны залгалт хийх мэс засал | 36.10, 39.61 | Артери венийн даралт хэмжигч датчик | S0007 | 92,000 | 69,000 |
| | | | | | Хүүхдийн оксигенаторын багц | S0004 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтертэй/ | S0005 | 2,100,000 | 1,575,000 |
| | | | | | Том хүний оксигенаторын багц /ультрафильтергүй/ | S0006 | 1,800,000 | 1,350,000 |
| 3.3 | I20-29 | Зүрхний агшилтын тоо цөөрөх, хэм алдагдах | Пейсмейкер суулгах | 37.7, 37.8 | Пейсмейкерийн багц | S0022 | 7,312,000 | 5,484,000 |
| 4. АРТЕРИЙН СУДАСНЫ ЭМГЭГҮҮДИЙН ҮЕИЙН МЭС ЗАСАЛ | | | | | | | | |
| 4.1 | I73-I78 | Захын судасны нарийсал | Захын судасны нарийсалд стент тавих /мөчний/ | 39.9, 00.40, 00.43, 00.45, 00.48 | Катетр | S0023 | 102,000 | 76,500 |
| 4.2 | I78-I83 | Хөлийн тараагуур судасны бөглөрөлтөт өвчин, цүлхэн, гэмтэл, судас хатуурах | Хөлийн судсыг хиймэл судсаар орлуулах | 38, 39 | Шулуун политетрафторэтилен хиймэл судас | S0024 | 900,000 | 675,000 |
| | | | | | Бөгжилсөн шулуун политетрафторэтилен хиймэл судас | S0025 | 1,400,000 | 1,050,000 |
| | | | Цавины артерийн нарийслийг засах | 39 | Нөхөөс | S0026 | 550,000 | 412,500 |
| 4.3 | I70-I72 | Гол судасны цүлхэн, судасны хатууралтат бөглөрөлтөт өвчин | Хиймэл судсаар орлуулах | 38.39 | Политетрафторэтилен аортын 2 салаа бифуркацитай хиймэл судас | S0027 | 1,200,000 | 900,000 |
| | | | | | Аортын шулуун политетрафторэтилен хиймэл судас | S0028 | 1,400,000 | 1,050,000 |
| | | | | | Аортын өгсөх хэсгийн шулуун политетрафторэтилен хиймэл судас | S0029 | 1,400,000 | 1,050,000 |
| | | | | | Шулуун политетрафторэтилен хиймэл судас | S0030 | 900,000 | 675,000 |
| 5. ТАРХИ, МЭДРЭЛИЙН МЭС ЗАСАЛ | | | | | | | | |
| 5.1 | I 60 | Тархины аалзан хальсан дор цус харвалт | Тархины артерийн цүлхэнгийн мэс засал | 2.1 | Гавлын яс бэхлэгч титан нөхөөс | S0031 | 560,400 | 420,300 |
| | | | | | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |
| | | | | | Титан нөхөөс | S0033 | 510,800 | 383,100 |
| 5.2 | I61.1; I61.4; | Тархины цус харвалт | Тархины харвалтын мэс | | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | I61.6; I61.8 | | засал | 1.4 | Титан нөхөөс | S0033 | 332,400 | 249,300 |
| 5.3 | I62.0; I62.1 | Тархины хатуу хальсан дээр, доорх цус харвалт | Тархины хатуу хальсны дээр, доорх цус хуралтын мэс засал | 1.3 | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |
| | | | | | Титан нөхөөс | S0034 | 684,800 | 513,600 |
| 5.4 | I77.0; Q27.3 | Тархины артери венийн гажиг | Тархины артери-венийн эмгэг сүлжээрлийн мэс засал | 2.1 | Хавчаар | S0035 | 618,000 | 463,500 |
| | | | | | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |
| | | | | | Титан нөхөөс | S0036 | 990,400 | 742,800 |
| | | | | | Шруп | S0037 | 45,200 | 33,900 |
| 5.5 | G50.0; G51.3; G52.4 | Мэдрэл, мэдрэлийн эмгэг, сүлжээрлийн эмгэг | Гавлын мэдрүүлийн мэс засал | 4.0 | Гавлын мэдрүүл тусгаарлагч | S0038 | 1,500,000 | 1,125,000 |
| | | | | | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |
| | | | | | Титан нөхөөс | S0039 | 1,116,800 | 837,600 |
| | | | | | Шруп | S0037 | 45,200 | 33,900 |
| 5.6 | G91; G93; Q03; G95.0 | Тархи усжих, Тархины бусад эмгэг, Төрөлх тархи усжих, Нугас хөндийрөх ба булцуу тархи хөндийдөх | Тархи, нугасны усжилт, уйланхайн мэс засал | 2.4 | Тархи-хэвлийн хөндий холбосон, клапан бүхий зориулалтын гуурс | S0040 | 180,000 | 135,000 |
| | | | | | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |
| 5.7 | G55.1; M50; M51; M53.2; M46.2; S22; S32 | Мэдрэл, мэдрэлийн эмгэг, сүлжээрлийн эмгэг, дорсопати | Нугалам, жийргийн мэс засал | 4.4 | Сээр, бүсэлхий нурууны хиймэл диск /1 хос/ | S0041 | 1,624,400 | 1,218,300 |
| | | | | | Нугалмын бэхэлгээ 2 үе | S0042 | 2,346,400 | 1,759,800 |
| | | | | | Нугалмын бэхэлгээ 3 үе | S0043 | 3,248,800 | 2,436,600 |
| | | | | | Нугалмын бэхэлгээ 4 үе | S0044 | 4,151,200 | 3,113,400 |
| | | | | | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |
| 5.8 | M89; S02 | Гавал ба нүүрний ясны хугарал | Гавал яс нөхөх мэс засал | 2.1 | Титан нөхөөс | S0045 | 778,650 | 583,988 |
| | | | | | Цус тогтоогч | S0032 | 95,200 | 71,400 |
| | | | | | Шураг | S0046 | 37,200 | 27,900 |
| 5.9 | S22; S32 | Хавирга, өвчүү ба сээр хугарах, бүсэлхий нуруу ба аарцаг ясны хугарал | Нугалмыг нөхөн сэргээх мэс засал | 3.5 | Ясны цемент (наборын хамт) | S0047 | 436,800 | 327,600 |
| 5.10 | D33; | Тархи ба төв мэдрэлийн тогтолцооны бусад хэсгийн хоргүй хавдар | Тархины хавдрын мэс засал | 1.4 | Тархины хатуу хальсны нөхөөс | S0048 | 520000 | 390,000 |
| | | | | | Титан нөхөөс | S0039 | 1,116,800 | 837,600 |
| | | | | | Ликворын гуурс | S0049 | 1000000 | 750,000 |
| | | | | | Хавчаар | S0035 | 618000 | 463,500 |
| 6. БҮДҮҮН ШУЛУУН ГЭДЭСНИЙ МЭС ЗАСАЛ | | | | | | | | |
| 6.1 | K50-K63 | Бүдүүн шулуун гэдэсний өвчин | Бүдүүн шулуун гэдэс тайрах мэс засал | 45.4, 45.5, 45.6, 45.7, 45.8, 46, 48, 49 | Цагираг оёгч, тайрагч | S0050 | 1,330,000 | 997,500 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагч | S0051 | 840,000 | 630,000 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагчийн цэнэг | S0052 | 500,000 | 375,000 |
| 6.2 | I84 | Архаг шамбарам | Оёх багажаар шамбрамыг | 49.4, | Цагираг оёгч /PPH3/ | S0053 | 1,342,500 | 1,006,875 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайрч сойх | 49.5, 49.6, 49.7, 49.9 | Дурангийн эд, судас оёгч, тайрагч /Stapler Endo GIA 60/ | S0054 | 1,270,000 | 952,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагчийн цэнэг /Stapler Endo GIA 60/ | S0055 | 850,000 | 637,500 |
| **7. БӨӨРНИЙ МЭС ЗАСАЛ** | | | | | | | | |
| 7.1 | N20 | Бөөрний чулуу | Бөөрний чулуу бутлах, чулуу авах мэс засал | 55.04 | JJ гуурс /удаан хугацааны/ | S0056 | 385,000 | 288,750 |
| | | | | | JJ гуурс /богино хугацааны/ | S0057 | 72,000 | 54,000 |
| | | | | | Уян чиглүүлэгч | S0058 | 165,000 | 123,750 |
| | | | | | Дормагийн катетр | S0059 | 610,000 | 457,500 |
| 7.2 | C64 | Бөөрний хавдар | Бөөр авах, хэсэгчлэн тайрах мэс засал | 55.01, 55.3, 55.4, 55.5, 55.7, 55.9 | Шулуун оёгч, тайрагч | S0051 | 840,000 | 630,000 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагчийн цэнэг | S0052 | 500,000 | 375,000 |
| 7.3 | N21 | Шээлгүүрийн чулуу | Шээлгүүр чулуу авах мэс засал | 56 | Дормагийн катетр | S0059 | 610,000 | 457,500 |
| | | | | | JJ гуурс /богино хугацааны/ | S0057 | 72,000 | 54,000 |
| 7.4 | N35-36 | Шээлгүүрийн бөглөрөл, нарийсал | Шээлгүүрт байнгын гуурс, шээлгүүр сэтгэх, тэлэх | 56, 59 | JJ гуурс /удаан хугацааны/ | S0056 | 385,000 | 288,750 |
| | | | | | JJ гуурс /богино хугацааны/ | S0057 | 72,000 | 54,000 |
| 7.5 | N30-N39 | Давсагны эмгэг | Давсганд хийх дурангийн мэс заслууд | 57, 59 | Зүсэгч электрод /биполяр/ | S0060 | 385,000 | 288,750 |
| 7.6 | N40 | Түрүү булчирхайн эмгэг | Түрүү булчирхайн дурангийн мэс засал | 60 | Зүсэгч электрод /биполяр/ | S0060 | 385,000 | 288,750 |
| 7.7 | N87 | CIN II-III зэрэг | LEEP | 67.32 | LOOP гогцоо | S0061 | 450,000 | 337,500 |
| **8. ЧИХНИЙ ЭМГЭГИЙН МЭС ЗАСАЛ** | | | | | | | | |
| 8.1 | H74.1 | Дунд чихний наалдаст үрэвсэл | Сонсголын ясыг протезоор орлуулах | 20.9 | Сонсголын ясны протез | S0062 | 600,000 | 450,000 |
| **9. ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН МЭС ЗАСАЛ** | | | | | | | | |
| 9.1 | G54, M40-M54; S12, S13, S22, S23; S32, S33 | Хүзүү, сээр, бүсэлхий нурууны нугалам хоорондох дискийн эмгэг, нугалмын хугарал, мултрал | Хугарсан нугалмыг хэвийн байдалд оруулж, титанан бэхэлгээгээр бэхлэх, нугалмыг хөдөлгөөнгүй болгох, нугалам хоорондын дискийн эмгэгийг засах | 03.53, 81.00-81.09 | Титанин бэхэлгээний багц /педикуль шураг, род-голч бэхлэгч нум, холбогчийн хамт/ | S0063 | 1,624,400 | 1,218,300 |
| | | | | | Нугалмын бэхэлгээ 2 үе | S0064 | 2,346,400 | 1,759,800 |
| | | | | | Нугалмын бэхэлгээ 3 үе | S0065 | 3,248,800 | 2,436,600 |
| | | | | | Нугалмын бэхэлгээ 4 үе | S0066 | 4,151,200 | 3,113,400 |
| | | | | | Нугалмын бэхэлгээ 5 үе | S0067 | 5,053,600 | 3,790,200 |
| 9.2 | G54, M40-M54; S12, S13, S22, | Нугалам хоорондох дискийн эмгэг, нугалмын хугарал, | Хугарсан нугалмыг хэвийн байдалд оруулж, титанан бэхэлгээгээр бэхлэх, | 81.00-81.09 , 84.51 | Титан кейж /педикуль шураг, род-голч бэхлэгч нум, холбогч, титанан дискийн хамт/ | S0068 | 3,654,000 | 2,740,500 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | S23; S32, S33 | мултрал | нугалмыг хөдөлгөөнгүй болгох, нугалам хоорондын дискийн эмгэгийг засах /нугалмыг хөдөлгөөнгүй болгох хэрэгсэл суулгах/ | | Титан кейж /педикуль шураг, род-голч бэхлэгч нум, холбогч, титанан дискийн хамт/ 2 үе | S0069 | 4,900,000 | 3,675,000 |
| 9.3 | S42, S52, S62, S72, S82, S92 | Шуу боггос хугарах | Хугарлыг ил аргаар засаж, ясны дотор бэхэлгээ тавих | 79.30-79.39 | Түгжээт хадаас, металл бэхлэгч /дистал ялтас, түгжээт хадаас, метуз хадаас, шахагч шураг, хамт шураг, металл ялтас, бэхлэгч, өнцөгт титан ялтас, өнцөгт титан ялтасны шураг/ | S0070 | 812,000 | 609,000 |
| 9.4 | M89, T90.5, S02,S06 | Гавлын ясны дутмагшил | Гавлын ясны дутмагшлыг титан нөхөөсөөр нөхөх мэс засал | 02.05 | Титан нөхөөс /титан нөхөөс, шөрөг, педикуль шурагийн хамт/ | S0071 | 1,256,400 | 942,300 |
| 9.5 | S02.4, S02.6, S02.8 | Шанааны ясны хугарал | Яс хадах | 76.71, 76.72 | Ялтас шурагийн хамт /ялтас шураг, бэхлэгч, холбогч/ | S0072 | 1,200,000 | 900,000 |
| | | Эрүүний ясны хугарал | Яс хадах | 76.75, 76.76 | Ялтас шурагийн хамт /ялтас шураг, бэхлэгч, холбогч/ 1 хугарал | S0073 | 1,200,000 | 900,000 |
| | | | | | Ялтас шурагийн хамт /ялтас шураг, бэхлэгч, холбогч/ 2 хугарал | S0074 | 2,400,000 | 1,800,000 |
| | | Нүдний ухархайн хугарал | Яс хадах | 76.78 76.79 | Ялтас шурагийн хамт /ялтас шураг, бэхлэгч, холбогч/ | S0075 | 1,424,000 | 1,068,000 |
| | | Хоншоор ясны хугарал | Яс хадах | 76.73 76.74 | Ялтас шурагийн хамт /ялтас шураг, бэхлэгч, холбогч/ | S0076 | 1,424,000 | 1,068,000 |
| 10. ЕРӨНХИЙ МЭС ЗАСАЛ | | | | | | | | |
| 10.1 | K20-23, C15 | Улаан хоолойн өвчин | Улаан хоолойг тайрч залгах мэс засал /улаан хоолойг тайрч залгах, нарийн гэдэс, бүдүүн гэдэс, ходоодоор орлуулах. Энэ мэс заслыг нээлттэй, эсвэл дурангийн аргаар, мөн хавсарсан аргаар хийж болно. | 42 | Цагираг оёгч, тайрагч | S0050 | 1,330,000 | 997,500 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагч | S0051 | 840,000 | 630,000 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагчийн цэнэг | S0052 | 500,000 | 375,000 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагч /Stapler Endo GIA 60/ | S0055 | 1,270,000 | 952,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагчийн цэнэг /Stapler Endo GIA 60/ | S0056 | 356,000 | 267,000 |
| | | | | | Троакар /нэг удаагийн/ | S0077 | 80,000 | 60,000 |
| | | | | | Угааж соруулах гар | S0078 | 280,000 | 210,000 |
| | | | | | Эрхтэн гаргагч уут | S0079 | 150,000 | 112,500 |
| | | | | | Цээжний шингэн цуглуулах сав | S0080 | 200,000 | 150,000 |
| | | | | | Цээжний хөндийн гуурс | S0081 | 50,000 | 37,500 |
| 10.2 | k25-31, C16 | Ходоодны эмгэгүүд | Ходоодыг хэсэгчлэн тайрч дээрх гэдэстэй залгах Бильрот I, Ходоодыг хэсэгчлэн тайрч өлөн гэдэстэй залгах Бильрот II, Ходоодыг бүтэн тайрч, улаан хоолой нарийн гэдсийг залгах, ходоод | 43, 44 | Цагираг оёгч, тайрагч | S0050 | 1,330,000 | 997,500 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагч | S0051 | 840,000 | 630,000 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагчийн цэнэг | S0052 | 500,000 | 375,000 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагч /Stapler Endo GIA 60/ | S0055 | 1,270,000 | 952,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагчийн цэнэг /Stapler Endo GIA 60/ | S0056 | 356,000 | 267,000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нарийн гэдсийг залгах, ходоодны эмгэг хэсгийг тайрч авах | | Троакар /нэг удаагийн/ | S0077 | 80,000 | 60,000 |
| | | | | | Угааж соруулах гар | S0078 | 280,000 | 210,000 |
| | | | | | Эрхтэн гаргагч уут | S0079 | 150,000 | 112,500 |
| 10.3 | К50-63, С17 | Гэдэсний эмгэгүүд | Нарийн болон бүдүүн гэдсийг хэсэгчлэн эсвэл бүтнээр тайрах, хооронд нь залгах, гэдэсний зориудын цорго гаргах (түр хугацааны эсвэл байнгын) | 45, 46 | Цагираг оёгч, тайрагч | S0050 | 1,330,000 | 997,500 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагч | S0051 | 1,330,000 | 997,500 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагчийн цэнэг | S0052 | 1,134,000 | 850,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагч /Stapler Endo GIA 60/ | S0055 | 1,270,000 | 952,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагчийн цэнэг /Stapler Endo GIA 60/ | S0056 | 356,000 | 267,000 |
| | | | | | Троакар /нэг удаагийн/ | S0077 | 80,000 | 60,000 |
| | | | | | Угааж соруулах гар | S0078 | 280,000 | 210,000 |
| | | | | | Эрхтэн гаргагч уут | S0079 | 150,000 | 112,500 |
| 10.4 | К70-77, С22 | Элэгний өвчин | Элэгний дэлбэн тайрах, элэгний эмгэгийг энукляци хийж авах болон цөсний замыг нөхөн сэргээх мэс засал | 50 | Цагираг оёгч, тайрагч | S0050 | 1,330,000 | 997,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагч /Stapler Endo GIA 60/ | S0055 | 1,270,000 | 952,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагчийн цэнэг /Stapler Endo GIA 60/ | S0056 | 356,000 | 267,000 |
| | | | | | Троакар /нэг удаагийн/ | S0077 | 80,000 | 60,000 |
| | | | | | Угааж соруулах гар | S0078 | 280,000 | 210,000 |
| | | | | | Эрхтэн гаргагч уут | S0079 | 150,000 | 112,500 |
| 10.5 | К85-86, С25 | Нойр булчирхайн эмгэгүүд | Нойр булчирхайг тайрах Whipple -ийн мэс засал | 52 | Шулуун оёгч, тайрагч | S0051 | 840,000 | 630,000 |
| | | | | | Шулуун оёгч, тайрагчийн цэнэг | S0052 | 500,000 | 375,000 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагч /Stapler Endo GIA 60/ | S0055 | 1,270,000 | 952,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагчийн цэнэг /Stapler Endo GIA 60/ | S0056 | 850,000 | 637,500 |
| 10.6 | J47, J60-J98, С34 | Гуурсан хоолой болон уушигны эмгэгүүд | Уушигны дэлбэн тайрах, оёх, цээжний хөндийд гуурс тавих | 32,33,34 | Дурангийн эд, судас оёгч, тайрагч /Stapler Endo GIA 60/ | S0055 | 1,270,000 | 952,500 |
| | | | | | Дурангийн эд, судас оёгч, тайрагчийн цэнэг /Stapler Endo GIA 60/ | S0056 | 850,000 | 637,500 |
| | | | | | Троакар /нэг удаагийн/ | S0077 | 80,000 | 60,000 |
| | | | | | Угааж соруулах гар | S0078 | 280,000 | 210,000 |
| | | | | | Эрхтэн гаргагч уут | S0079 | 150,000 | 112,500 |
| 10.7 | Е26-Е27, С74 | Бөөрний дээд булчирхайн эмгэг | Бөөрний дээд булчирхайд хийгдэх мэс засал | 07.0-07.4 | Троакар /нэг удаагийн/ | S0077 | 80,000 | 60,000 |
| | | | | | Угааж соруулах гар | S0078 | 280,000 | 210,000 |
| | | | | | Эрхтэн гаргагч уут | S0079 | 150,000 | 112,500 |
| 10.8 | D73, С26.1 | Дэлүүний өвчин | Дэлүүнд хийгдэх мэс | 41.2, | Шулуун оёгч, тайрагч | S0051 | 840,000 | 630,000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | засал | 41.3, 41.4, 41.5, 41.9 | Шулуун оёгч, тайрагчийн цэнэг | S0052 | 500,000 | 375,000 |
| 11.ХИЙМЭЛ ҮЕ СУУЛГАХ МЭС ЗАСАЛ | | | | | | | | |
| 11.1 | M15-M19, M23-25 | Остеоартроз, өвдөг, түнхний үенд эдгэшгүй өөрчлөлт орсон, түнхний төрөлхийн гаж хөгжил, ясны үхжил, хавдар, ясны эдийн их хэмжээний дутмагшил | Өвдөгний үенд хиймэл үе суулгах мэс засал | 81.54 | Өвдөгний хиймэл үе | S0082 | 6,500,000 | 4,875,000 |
| | | | Түнхэнд хиймэл үе суулгах мэс засал | 81.51, 81.52, | Түнхний хиймэл үе | S0083 | 7,000,000 | 5,250,000 |
| 11.2 | S72 | Дунд чөмөгний хүзүүний эмгэг хугарал | Хугарсан толгойг авч хиймэл үе суулгах | 81.51 81.52 | Хоёр туйлт хиймэл үе | S0084 | 6,745,000 | 5,058,750 |

--- o O o ---

*Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 06 дугаар сарын 26 -ний өдрийн 248/161/А/88 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт*

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ӨНДӨР ӨРТӨГ БҮХИЙ ЗАРИМ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, СЭРГЭЭН ЗАСАХ ЗОРИУЛАЛТААР ХИЙГДЭХ ПРОТЕЗИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1. Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн зардлын төлбөрийг нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн зардлын төлбөрийг нь санхүүжүүлэхдээ Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез (цаашид "Эмнэлгийн хэрэгсэл, протез" гэх)-ийн жагсаалт, даатгалын сангаас олгох зардлын хэмжээ"-г баримтална.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь энэ журмын 1.2-т заасан Эмнэлгийн хэрэгсэл, протезийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

1.4.Эрүүл мэнд, спортын яам, Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын байгууллага болон даатгуулагч нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн чанар, эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагч өөрөө хариуцан төлөх төлбөрийн хэмжээ зэрэгт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавина.

**Хоер. Удирдлага зохион байгуулалт**

2.1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн жагсаалт, үнийг судлах, санал боловсруулах үүрэг бүхий байнгын бус ажиллагаатай ажлын хэсэг ажиллуулж болох бөгөөд ажлын хэсэг нь эрүүл мэндийн, санхүү төсвийн, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын төв байгууллага, эрүүл мэндийн байгууллага, даатгуулагчийн төлөөллөөс бүрдэнэ.

2.2. Ажлын хэсэг нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.2.1. Энэхүү журмаар зохицуулсан эмнэлгийн хэрэгсэл, протезийн жагсаалтыг өвчлөлийн байдал, даатгуулагчийн хэрэгцээ, эрүүл мэндийн даатгалын сангийн чадавхи, орлогын бүрэлдэхүүнтэй холбогдуулан шинэчлэх, өөрчлөлт оруулах санал боловсруулах;

2.2.2. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн жишиг үнэ, даатгалын сангаас олгох хэмжээг хэрэглээний үнийн өөрчлөлт, инфляцийн түвшинтэй уялдуулан судалж, шинэчлэх санал боловсруулж, холбогдох газарт уламжлах;

2.2.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хувь хэмжээг судалгаа тооцооны үндсэн дээр шинэчлэх санал боловсруулах;

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчид үзүүлж буй тусламж, үйлчилгээний байдалд явцын үнэлгээ, тооцоо судалгаа хийж, дүгнэлт гаргах, саналаа илэрхийлэх.

2.3. Ажлын хэсэг нь 2.2.1-2.2.4-т заагдсан үйл ажиллагааны талаар дүгнэлт гарган, дараа жилийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахаас өмнө буюу жил бүрийн хоёрдугаар улиралд багтаан Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх, эрүүл мэндийн, санхүү төсвийн, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад санал хүргүүлэн хамтран ажиллана.

## Гурав. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн зардлын төлбөр

3.1. Энэхүү журмын 1.2-т заасан даатгуулагчийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протезийг тухайн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага хангана.

3.2.Эмнэлгийн хэрэгсэл, протезийн зардлын төлбөрийг Нийгмийн даатгалын байгууллага энэ журмын 1.2-т заасан хэмжээгээр тооцон тухайн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагад даатгалын сангаас олгож, үлдэх хэсгийг даатгуулагч өөрөө хариуцан төлнө.

3.3 Энэ журмын 1.2-т заасан эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн даатгуулагчийн төлөх төлбөрийг "Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үнэ"-ээс эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх хэмжээг хассан зөрүүгээр тооцно.

3.4. Дараах тохиолдолд эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийг даатгалын сангаас төлөхгүй. Үүнд:

3.4.1. Эрүүл мэндийн байгууллага нь техникийн үзүүлэлтийн шаардлага хангаагүй, баталгаагүй, чанаргүй эмнэлгийн хэрэгсэл, протез хэрэглэсэн нь эрх бүхий байгууллагаар нотлогдсон;

3.4.2. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн алдааны улмаас өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл, протезийг дахин хэрэглэх шаардлагатай болсон нь эрх бүхий байгууллагаар нотлогдсон;

3.4.3. Даатгуулагчийн буруутай үйл ажиллагаанаас болж өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл, протезийг дахин хэрэглэсэн тухай Эмчилгээний чанарын хяналтын комиссын шийдвэр гарсан.

## Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүрэг

4.1. Тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

4.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтад орж эрх авсан байгууллагаас техникийн үзүүлэлтийн шаардлага хангасан, баталгаатай чанартай эмнэлгийн хэрэгсэл, протезийг худалдан авах, хэрэглэх;

4.1.2. Эрүүл мэндийн байгууллагын тендерийн Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллагын төлөөллийг оролцуулах;

4.1.3. Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллах;

4.1.4. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн төлбөрийн нэхэмжлэлийг "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ"-нд заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх;

4.1.5. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийг нийгмийн даатгалын байгууллагаас нэхэмжлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлэх:

а. Тухайн мэс засал хийлгэсэн даатгуулагчийн өвчний түүх;

б. Энэ журмын 5.1.2-д заасан тэмдэглэл хүснэгтийн дагуу гаргасан мэдээлэл;

в. Эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн даатгуулагчийн өөрөө хариуцан төлсөн төлбөрийн баримтын нэг хувь.

4.1.6. Тухайн мэс засалд хэрэглэсэн эмнэлгийн хэрэгсэл, протезийн үйлдвэрийн бар код, сери дугаарыг энэ журмын 5.1.2-д заасан тэмдэглэл хүснэгтэд бичих буюу наасан байх;

4.1.7. Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагч өөрөө хариуцан төлөх төлбөрийн хэмжээний талаар даатгуулагчдыг тодорхой мэдээллээр хангах;

4.1.8.Энэхүү журмаар зохицуулсан заалтаас бусад нэмэлт төлбөр даатгуулагчаас авахыг хориглох.

## Тав. Нийгмийн даатгалын байгууллагын хүлээх үүрэг

5.1.Нийгмийн даатгалын байгууллага дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.1.1 Нийгмийн даатгалын байгууллага нь "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ" байгуулсан эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчийн мэс заслын тусламж, үйлчилгээнд хэрэглэсэн эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн төлбөрийг энэ журмын 4.1.5-д заасан баримт бичгийг хянан шалгасны үндсэн дээр гүйцэтгэлээр тооцон баталсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх;

5.1.2.Нийгмийн даатгалын байгууллага нь "Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сэргээн засах зориулалтаар хийгдэх протезийн тухай тэмдэглэл хүснэгт"-ийн загварыг батлана.

5.1.3. Нийгмийн даатгалын байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн үнийн төлбөрийн санхүүжилтийг энэ журам болон дараах эрх зүйн акт, баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:

а. Энэ журмын 1.2-т заасан эрүүл мэндийн даатгалын сангаас олгох хэмжээ;

б. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн энэ журмын 4.1.5-д заасан баримт бичиг;

в. Шилэн дансны тухай хуулийн дагуу худалдан авсан эмнэлгийн хэрэгсэл, протезийн талаарх эрүүл мэндийн байгууллагын гаргасан мэдээлэл.

5.1.4. Нийгмийн даатгалын байгууллага нь эмнэлгийн хэрэгсэл, протезийн үйлдвэрийн бар код, сери дугаар, мэдээллийн сан, хяналтын програм хангамж, даатгуулагчийн мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын анхан шатны баримт бичиг зэрэгт эмнэлгийн хэрэгсэл, протезийн тендерийн гэрээний үнэ, даатгуулагчид үзүүлж байгаа үнийн хөнгөлөлт, хамтын төлбөрийн асуудалд хяналт тавьж, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгах, даатгуулагчийн гомдлыг барагдуулж хохиролгүй болгох зэрэг хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

5.1.5. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 4.1.1-д заасан худалдан авалтын талаарх мэдээлэл (тендер зарлах үйл явц, үнэлгээний хорооны шийдвэр, тендерт шалгарсан байгууллагын нэр, танилцуулга, уг байгууллагаас нийлүүлэх эмнэлгийн хэрэгсэл, протезийн нэр, үнийн мэдээлэл)-ийг Шилэн дансны хуулийн дагуу тухайн эрүүл мэндийн байгууллагын цахим хуудаснаас авна.

## Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журам болон “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ”-гээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, даатгуулагчаас илүү төлбөр авсан, даатгуулагчид чанар, техникийн үзүүлэлтийн шаардлага хангаагүй эмнэлгийн хэрэгсэл, протез хэрэглэсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авсан нь нотлогдсон тохиолдолд тухайн албан тушаалтан, байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- o O o ---